



**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ**

2019 оны 03 сарын 19 өдөр

Дугаар 24

Номгон

Орон сууцны цэвэрлэгээ, үйлчилгээний  
хураамжийг тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2, 18 дугаар зүйлийн 18.1.2-ын “д”, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр 64.1, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3, 41 дүгээр зүйлийн 41.7, Эрүүл ахуйн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ** нь:

1. “Цэвэр хот” ОНӨХХК-д харъяалагдан цэвэрлэгээ, үйлчилгээ хийгдэж байгаа орон сууцнуудын орц цэвэрлэгээний хөлсийг өрх тус бүрээр сарын 5000 /таван мянган/ төгрөгөөр тогтоосугай.
2. Цэвэрлэгээ үйлчилгээний хөлс болох 5000 /таван мянган/ төгрөгийг “Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК-ний цахилгааны төлбөр дээр хураан авч холбогдох дансанд төвлөрүүлэн ажиллахыг “Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК-ний гүйцэтгэх захирал /Т.Отгонбаатар/-д үүрэг болгосугай.
3. Цэвэрлэгээ, үйлчилгээний орлогыг холбогдох хууль тогтоомжийн дагуу бүрдүүлэх, захиран зарцуулах ажлыг зохион байгуулж ажиллахыг “Цэвэр хот” ОНӨХХК-ний гүйцэтгэх захирал /Ц.Баясгалан/-д даалгасугай.
4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч /Т.Эрдэнэбат/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Ц.ОТГОНБАЯР